



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/412

Номгон

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, "Газрын тухай" хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 61 дүгээр зүйлийн 61.1, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 113 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2015 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 309 дүгээр захирамжийн 1 дүгээр заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай.

2. Баянхонгор сум, Номгон 1-р баг, Чандмань гудамж-1, 110 тоот хаягт байршилтай иргэн Ч.Чимэг-Очирын /ВЮ60103116/ эзэмшиж буй 791 м2 талбайтай эзэмшил газар дээр 288 м2 газрыг нэмж эзэмшүүлж, зориулалтыг нь үйлчилгээтэй орон сууц болгон өөрчилсүгэй.

3. Эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

4. Эзэмшил газрын зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621011037